



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ахлах сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/176/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ч.ЦЭЦГЭЭ ТАНАА

ᠠᠷᠠᠨᠭᠠᠢ.ᠠᠶᠢᠮᠠᠭ.ᠳᠠᠬᠤ № ᠕7
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна..

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг..

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



T. Baygalmaa

Т.БАЙГАЛМАА



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>170,292,931.98</u>	<u>189,842,562.51</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	479,759.29	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	479,759.29	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	169,813,172.69	189,842,562.51
351	Түүхий эд материал	237,000.00	353,900.00
35130	Эм боох материал	237,000.00	353,900.00
354	Хангамжийн материал	151,126,172.69	169,753,662.51
35410	Бичиг хэргийн материал	709,160.00	637,260.00
35420	Аж ахуйн материал	122,966,075.53	140,045,465.35
35440	Түлш, шатах тослох материал	670,020.16	2,290,020.16
35450	Барилгын засварын материал	250,000.00	250,000.00
35470	Бусад хангамжийн материал	26,530,917.00	26,530,917.00
35600	Мал амьтад	18,450,000.00	19,735,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,693,572,955.06	6,543,716,465.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,693,572,955.06	6,543,716,465.48
392	Биет хөрөнгө	6,577,818,955.06	6,427,962,465.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,415,033,458.26	7,324,392,315.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,041,168,609.01	-1,161,243,946.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,700,000.00	29,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,732,500.00	-4,702,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	229,886,350.16	224,178,184.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-146,427,005.67	-101,576,481.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	267,415,336.14	252,097,541.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	-215,995,350.50	-178,660,413.56
39217	Ном	41,107,275.68	43,777,765.76
393	Биет бус хөрөнгө	115,754,000.00	115,754,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	115,754,000.00	115,754,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,863,865,887.04</u>	<u>6,733,559,027.99</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,863,865,887.04</u>	<u>6,733,559,027.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,863,865,887.04	6,733,559,027.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,033,917,592.76	1,033,917,592.76
51101	Өмч: - төрийн	1,033,917,592.76	1,033,917,592.76
512	Хуримтлагдсан үр дүн	4,506,843,634.95	4,376,536,775.90
51210	Өмнөх үеийн үр дүн	4,506,843,634.95	4,506,843,634.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-130,306,859.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,323,104,659.33	1,323,104,659.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,863,865,887.04</u>	<u>6,733,559,027.99</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,835,406,934.92	1,801,948,696.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	132,353,934.92	169,642,032.87
120	Нийтлэг татварын бус орлого	132,353,934.92	169,642,032.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	132,353,934.92	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	131,753,934.92	00.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	00.00	141,785,782.87
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	00.00	27,256,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	133,327,800.00	62,104,263.64
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,569,725,200.00	1,570,202,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,823,300.00	2,859,763.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,823,300.00	2,859,763.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,504,500.00	59,244,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,504,500.00	59,244,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,891,029,392.68	1,932,255,555.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,891,029,392.68	1,932,255,555.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,838,053,185.72	1,892,184,808.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,269,269,757.20	1,219,329,810.63
210101	Үндсэн цалин	1,267,269,757.20	991,902,310.63
210102	Нэмэгдэл	2,000,000.00	120,225,636.66
210104	Урамшуулал	00.00	107,201,863.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,005,376.55	155,283,548.71
210201	Тэтгэврийн даатгал	95,099,271.55	155,159,342.71
210202	Тэтгэмжийн даатгал	12,505,841.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,986,395.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,501,169.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,912,700.00	124,206.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,694,500.00	62,924,500.00
210301	Гэрэл, цахилгаан	14,417,500.00	17,060,517.00
210302	Түлш, халаалт	107,297,000.00	44,563,983.00
210303	Цэвэр, бохир ус	980,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,351,475.00	55,489,583.82
210401	Бичиг хэрэг	3,994,075.00	5,564,663.64
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,428,800.00	732,700.00
210404	Ном, хэвлэл	3,943,300.00	451,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	655,900.00	1,794,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,800.00	630,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	15,036,600.00	46,315,720.18
2105	Норматив зардал	77,429,400.00	85,001,053.00

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	788,600.00	7,641,400.00
210502	Хоол, хүнс	58,919,700.00	64,367,353.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,721,100.00	12,992,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,307,100.00
210604	Урсгал засвар	00.00	1,307,100.00
2107	Томилолт, зочны зардал	404,900.00	283,600.00
210702	Дотоод албан томилолт	404,900.00	283,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,999,050.00	5,761,640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,199,050.00	4,961,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,898,726.97	306,803,972.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,731,730.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,425,100.00	1,461,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	186,741,896.97	305,342,272.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,976,206.96	40,070,746.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,459,200.00	35,472,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,642,700.00	35,211,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	816,500.00	261,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,517,006.96	4,597,946.95
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,517,006.96	4,597,946.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-55,622,457.76	-130,306,859.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25,229,651.30	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-25,229,651.30	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-80,852,109.06	-130,306,859.05

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	903,907,735.76	368,213,743.30	1,136,882,919.21	2,409,004,398.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,377,700,000.00	-1,377,700,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	903,907,735.76	368,213,743.30	-240,817,080.79	1,031,304,398.27
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,702,856.95	-1,702,856.95
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,033,917,592.76	1,323,104,659.33	4,506,843,634.95	6,863,865,887.04
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,033,917,592.76	1,323,104,659.33	4,506,843,634.95	6,863,865,887.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,033,917,592.76	1,323,104,659.33	4,506,843,634.95	6,863,865,887.04
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-130,306,859.05	-130,306,859.05
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,033,917,592.76	1,323,104,659.33	4,376,536,775.90	6,733,559,027.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,703,653,000.00	1,632,906,663.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,703,053,000.00	1,632,306,663.64
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,569,725,200.00	1,570,202,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,823,300.00	2,859,763.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,823,300.00	2,859,763.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	129,504,500.00	59,244,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	129,504,500.00	59,244,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,703,340,300.00	1,619,206,663.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,703,340,300.00	1,619,206,663.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,649,561,893.04	1,577,846,916.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,247,185,200.00	1,215,654,888.00
210101	Үндсэн цалин	864,994,175.00	884,220,688.00
210102	Нэмэгдэл	266,066,625.00	227,427,500.00
210104	Урамшуулал	116,124,400.00	104,006,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,569,693.04	158,478,712.05
210201	Тэтгэврийн даатгал	117,732,500.00	97,815,996.97
210202	Тэтгэмжийн даатгал	12,721,800.00	10,922,911.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,177,500.00	22,601,864.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,894,300.00	5,478,716.80
210205	Эрүүл мэндийн даатгал	25,043,593.04	21,659,222.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	124,504,500.00	59,244,500.00
210301	Гэрэл, цахилгаан	17,507,500.00	17,060,517.00
210302	Түлш, халаалт	101,237,000.00	40,883,983.00
210303	Цэвэр, бохир ус	5,760,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,861,900.00	15,593,763.64
210401	Бичиг хэрэг	1,406,700.00	2,224,763.64
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	4,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,984,400.00	892,600.00
210404	Ном, хэвлэл	4,600,700.00	609,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,072,100.00	2,060,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,798,000.00	5,805,900.00
2105	Норматив зардал	71,275,900.00	103,671,853.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,801,700.00	17,675,400.00
210502	Хоол, хүнс	57,614,800.00	64,367,353.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,859,400.00	21,629,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	6,500,000.00

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210602	Тавилга	00.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	755,600.00	283,600.00
210702	Дотоод албан томилолт	755,600.00	283,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,866,900.00	12,180,598.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,066,900.00	10,766,498.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	1,414,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,542,200.00	6,239,002.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,542,200.00	6,239,002.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,778,406.96	41,359,746.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,261,400.00	36,761,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,993,400.00	35,211,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,517,006.96	4,597,946.95
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,517,006.96	4,597,946.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>312,700.00</u>	<u>13,700,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>312,700.00</u>	<u>13,700,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>312,700.00</u>	<u>13,700,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	312,700.00	13,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	312,700.00	13,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-312,700.00</u>	<u>-13,700,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

	Үзүүлэлт	Тайлант оны	Зөрүү
--	----------	-------------	-------

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,630,046,900.00	1,625,448,953.05	4,597,946.95	99.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,630,046,900.00	1,625,448,953.05	4,597,946.95	99.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,592,433,600.00	1,588,687,153.05	3,746,446.95	99.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,215,654,888.00	1,215,654,888.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	884,220,688.00	884,220,688.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	227,427,500.00	227,427,500.00	0.00	100.00
210104	Урамшуулал	104,006,700.00	104,006,700.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,489,800.00	158,478,712.05	3,011,087.95	98.14
210201	Тэтгэврийн даатгал	117,734,200.00	97,815,996.97	19,918,203.03	83.08
210202	Тэтгэмжийн даатгал	10,938,900.00	10,922,911.64	15,988.36	99.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,751,100.00	22,601,864.10	-13,850,764.10	258.27
210204	Ажилгүйдлийн даатгал	2,187,800.00	5,478,716.80	-3,290,916.80	250.42
210205	Эрүүл мэндийн даатгал	21,877,800.00	21,659,222.54	218,577.46	99.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,244,500.00	59,244,500.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	16,707,500.00	17,060,517.00	-353,017.00	102.11
210302	Түлш, халаалт	41,237,000.00	40,883,983.00	353,017.00	99.14
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,734,000.00	12,734,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	800,200.00	800,200.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	892,900.00	892,600.00	300.00	99.97
210404	Ном, хэвлэл	609,800.00	609,800.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	625,500.00	625,500.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,805,600.00	5,805,900.00	-300.00	100.01
2105	Норматив зардал	104,407,212.00	103,671,853.00	735,359.00	99.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,675,400.00	17,675,400.00	0.00	100.00

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	65,102,712.00	64,367,353.00	735,359.00	98.87
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,629,100.00	21,629,100.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,200,000.00	20,200,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,200,000.00	12,200,000.00	0.00	100.00
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	283,600.00	283,600.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	283,600.00	283,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,363,500.00	12,180,598.00	182,902.00	98.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,563,500.00	10,766,498.00	797,002.00	93.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	1,414,100.00	-614,100.00	176.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6056100.00	6239002.00	-182,902.00	103.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,056,100.00	6,239,002.00	-182,902.00	103.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37613300.00	36761800.00	851,500.00	97.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,613,300.00	36,761,800.00	851,500.00	97.74
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,063,300.00	35,211,800.00	851,500.00	97.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,630,046,900.00	1,625,448,953.05	4,597,946.95	99.72
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,570,202,400.00	1,565,604,453.05	4,597,946.95	99.71
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,570,202,400.00	1,565,604,453.05	4,597,946.95	99.71
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,244,500.00	59,244,500.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	59,244,500.00	59,244,500.00	0.00	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	600,000.00	600,000.00	0.00	100.00

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	106	106		100
620001	Удирдах ажилтан	1	1		100
620002	Гүйцэтгэх ажилтан	65	65		100
620003	Үйлчлэх ажилтан	40	40		100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,823,300.00	2,859,763.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,823,300.00	2,859,763.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,823,300.00	2,859,763.64
2104	Хангамж, бараа материалын зардал	3,823,300.00	2,859,763.64
210401	Бичиг хэрэг	3,823,300.00	1,424,563.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,435,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,823,300.00	2859763.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,823,300.00	2,859,763.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,823,300.00	2,859,763.64
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймаг Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагааг эрүүл аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн танхимын болон цахим хэлбэрээр тасралтгүй, чанартай зохион явуулж, суралцагчийг сурлагаар хоцрогдох, хичээл завсардахаас сэргийлэн, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, багш өөрийн мэргэжлээр тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилсан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв,

хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн сая 1,630.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 16.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130.3 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан өөрчлөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.5		0.5
Бараа материал	169.8	189.8	20.0
Үндсэн хөрөнгө	6,693.8	6,543.7	-149.9
Нийт хөрөнгө	6,863.9	6,733.6	-130.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,863.9	6,733.6	-130.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,863.9	6,733.6	-130.3

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Өмнөх оны ажилчдаас авах авлага барагдсан байна
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 11.8 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 169.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 172.7 сая төгрөг бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 27.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант онд 179.9 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 189.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2.2 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 6,693.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 13.7 сая төгрөг үндсэн хөрөнгө дахин үнэлсэнтэй холбоотой 141.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас 264.5 сая төгрөгийн хөрөнгө хассан, тайлант хугацааны элэгдэл 305.3 сая төгрөг, үндсэн хөрөнгийн дахин үнэлэхтэй холбоотойгоор данснаас 264.5 мянган төгрөгийн элэгдлийн зөрүү 40.9 мянган төгрөг хасагдаж 6,543.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 130.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд хөрөнгө дахин үнэлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
----------	----------	------------	----------

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,569.7	1,570.20	0.48
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	129.5	59.24	- 70.26
Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого	132.4	0.60	- 131.75
Нэмэлт санхүүжилтийн орлого	3.8	2.86	- 0.96
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		141.79	141.79
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		27.26	27.26
Үйл ажиллагааны орлого	1,835.4	1,801.95	- 33.46
Цалин, шимтгэлийн зардал	1,414.3	1,374.61	- 39.66
Бараа үйлчилгээний зардал	225.9	205.01	- 20.87
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3.0	5.76	2.76
Бараа үйлчилгээний бусад зардал	194.9	306.80	111.91
Урсгал шилжүүлэг	53.0	40.07	- 12.91
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25.2		- 25.23
Үйл ажиллагааны зардал	1,916.3	1,932.26	16.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-80.9	-130.31	- 49.45

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 70.3 сая төгрөг буюу 54.3 хувиар буурсан нь цар тахалтай холбоотой хөл хориотой байсан үеийн байрны хоол, үдийн цайны санхүүжилт буурсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,630.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 1,630.1 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,630.1 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,630.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,625.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,625.0 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 2.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2021 онд “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас

сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой сургууль орчмын бүс, сургалтын байр анги танхимд 2 цаг тутам цэвэрлэгээ, 5 хоногт 1 удаа ариутгал хийж ажилласан байна.

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар сумын төвийн төсөвт байгууллагууд болон ААНБ-уудыг нэгдсэн дулааны шугам татаж, сургуулийн уурын зуухны барилгатай холбон “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ байгуулж сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Уурын зуухны барилгын үйл ажиллагааг шилжүүлэн авч ашиглаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-д зааснаар төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно гэснийг зөрчсөн байна. Үүнийг холбогдох эрх бүхий байгууллагууд нарийвчлан шалгаж үзэх шаардлагатай гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 1,630.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,625.0 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.7 хувь байна.

Тус байгууллага нь өөрийн орлогыг 0.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.6 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлжээ. Энэ нь туслах аж ахуйгаас орж ирсэн орлого байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2.Суудлын автомашин ашиглалтын хувьд: 35-07 АРА улсын дугаартай 2017 онд үйлдвэрлэгдсэн 29.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий фургон автомашинтай бөгөөд шатахууны зардалд 4.0 сая төгрөгийг батлуулж, 4.0 сая төгрөгийн зардал гаргасан байна. Орон тооны жолоочгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 142 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтын хүрээнд төсвийн хасагдах тодотгол хийснээр тус байгууллага нь 215.3 сая төгрөгийг зарцуулахаас гүйцэтгэлээр 214.6 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тогтоолын хүрээнд 21.5 сая төгрөгийн хэмнэлт гаргахаас 0.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 20.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй 20.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

2. Тус байгууллага нь тогтмол зардалд /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/ 59.2 сая төгрөг батлуулж, гүйцэтгэлээр 59.2 сая төгрөгийн зардал гаргаж, 11.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8-д заасан тогтмол зардалд 20-ис доошгүй хувийн хэмнэлт гаргах гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй 11.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нийт 206.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 43.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 162.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгө болон туслах аж ахуйн бүртгэлийг анхаарч үзэх

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 138.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 138.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулагдаагүй алдаа зөрчилгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

1. Тус байгууллага нь 136.0 сая төгрөгийн цалингийн зардлыг цалингийн өглөг дансаар дамжуулан бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13, 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг дагаж мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 136.0 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны

2 дугаар сарын 18-ний өдрийн №12 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

- Тооцооны дансаар 0.3 сая төгрөгийг дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг дагаж мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 0.3 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 18-ний өдрийн №12 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

- Худалдан авсан 2.2 сая төгрөгийн бараа материалыг орлого аваагүй шууд зардалд бүртгэсэн нь УСНББОУС-12 "Бараа материал", Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 2.2 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 18-ний өдрийн №12 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Эрдэнэмандал сумын Ерөнхий боловсролын сургууль	3	138.5	3	138.5	0	0	0	0	0	0
<u>Дүн</u>		3	138.5	3	138.5	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Эрдэнэ мандал сумын Ерөнхий боловсролын сургууль	3	32.6	0	0	0	0	3	32.6	0	0
<u>Дүн</u>		3	32.6	0	0	0	0	3	32.6	0	0
Нийт дүн		6	171.2	1	138.5	0	0	3	32.6	0	0